

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв



Шинэ
сургалт

БИЗНЕСИЙН СУРГАЛТЫГ ХЭРХЭН ҮР ДҮНТЭЙ ЗААХ ВЭ?

(Ахисан түвшний сургуулийн багш нарт зориулсан
заах арга зүйн семинар)

2025.09.25-26

2025 он

1) Танилцуулга:

Тус төв нь энэ хичээлийн шинэ жилээс эхлэн Японд төдийгүй дэлхийд чансаагаараа тэргүүлэх нэр хүндтэй их сургуулиудын профессоруудыг урьж бизнесийн тусгай сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Энэ ажлын хүрээнд Васэда их сургуулийн багш нар хүрэлцэн ирж, их дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт бизнесийн чиглэлээр сургалт ордог багш нар болон бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг консалтант нарт зориулан заах арга зүйн тусгай семинарыг зохион байгуулахаар болоод байна.

Бизнесийн боловсрол нь их сургуулийн оюутнуудад зориулсан боловсролоос өөр арга барил шаарддаг. Өөрөөр хэлбэл, зөвхөн багшийн зүгээс л оюутнуудад “лекц” унших нь үр дүнгүй. Харин багш, суралцагч хамтдаа суралцах орчныг бүрдүүлж, багш нь менежментийн онолын мэдлэгийг, суралцагчид өөрсдийн практик туршлагыг хуваалцаж, тэдгээрийг нэгтгэн “хамтын бүтээл” бий болгох нь илүү үр дүнтэй юм.

Сургалтын зорилго:

Энэхүү сургалтаар бизнесийн боловсролд багш суралцагчидтайгаа хэрхэн хамтран суралцах орчныг бий болгох тухай гол санаануудыг хуваалцаж, зарим ур чадварыг эзэмшүүлэх зорилготой.

2) Хугацаа: 2025.09.25/26 (Пүрэв-Баасан, 09:30-12:30), аль нэг өдрийг сонгох

3) Хамрагдах хүн: Магистр, докторын хөтөлбөрт бизнесийн чиглэлээр сургалт ордог багш нар болон бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг консалтант нар

4) Хамрагдах хүний тоо: 30 хүн

※Хүний тоо гүйцсэн тохиолдолд хугацаанаас өмнө бүртгэл дуусахыг анхаарна уу!

5) Сургалтын төлбөр: 75,000 төгрөг

6) Хичээл заах багш: Сато Кацүхиро (Ph.D)



Васэда Их Сургуулийн Бизнесийн Сургуулийн профессор

Кэйо Их Сургуулийн Хуулийн Факультетийг төгссөн. Станфордын Их Сургуулийн магистрын зэрэгтэй. Киотогийн Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын дээд сургуульд докторын зэрэг хамгаалсан (Ph.D, Менежментийн шинжлэх ухаан). Япон улсын Хөгжлийн Банк (одоогийн Япон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк) болон МакКинзи & Компанийн түнш зэрэг албан тушаалд ажиллаж байсан.

Одоо Васэдагийн Их Сургуулиас гадна Киотогийн Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын тэнхимд судалгаа, сургалтын ажил эрхэлж, Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн судалгааны хүрээлэнгийн зөвлөх судлаач, олон нийтийн сангийн удирдах зөвлөлийн гишүүн, компаниудад менежментийн зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаа явуулж байна. “Практик стратеги болох компанийн үнэлэмж” (Даймонд хэвлэлийн газар) зэрэг олон тооны ном бүтээл туурвисан.

7) Сургалтын хөтөлбөр:

Өдөр	Сэдэв	Агуулга	Цагийн хуваарь
9 сарын 25, 26 /Пүрэв, Баасан/	(1) Бизнесийн боловсролын арга зүй (1.5 цаг)	Бизнесийн боловсролд оролцогч төвтэй сургалт (participant-centered learning) болон хамт олноороо суралцах (peer learning) зэрэг суралцагчдын оролцоог хангасан сургалт илүү үр дүнтэй байдаг. Энэ хэсэгт бид эдгээр арга зүйн хүрээнд ① лекцийн материалыг бэлтгэх, ② лекц явуулах гол зөвлөгөөнүүдийг тайлбарлана. Тодруулбал, Васадагийн Бизнесийн Сургуульд багшийн заадаг "Бизнесийн стратеги" хичээлийг жишээ болгон авч, суралцагчдад үр дүнтэй мэдлэг олгох лекцийн материал бэлтгэх арга, видео хичээлийг ашиглах, суралцагчдын практик туршлагыг үр дүнтэйгээр ашиглах асуулт тавих, харилцан суралцах бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулах, хичээлийн агуулгыг практикт хэрэгжүүлэх бүлгийн ажлыг удирдах зэрэг арга зүйг тайлбарлана.	Хичээлийн цаг 09:30-12:30 Завсарлага 10:50-11:00 /10 мин/
	(2) Кейс судалгааны материалыг ашиглах нь (1.5 цаг)	Бизнесийн боловсролд Харвардын Бизнесийн Сургууль зэрэг дэлхийн томоохон бизнес сургуулиудын боловсруулсан “кейс судалгааны материал”-ыг ашиглан хэлэлцүүлэг өрнүүлэх нь үр дүнтэй байдаг. Кейс судалгааны материал гэдэг нь бодит компанийн бизнесийн жишээн дээр үндэслэн бэлтгэсэн материал бөгөөд багшийн удирдамжийн дор оюутнууд хэлэлцүүлэг хийж, практик мэдлэг олж авдаг. Энэ хэсэгт бид их сургуулийн багш нарыг оюутны дүрд тоглуулж, доорх кейс судалгааны материалыг хэлэлцүүлэгт оролцуулснаар кейс судалгааны аргаар сургах арга зүйг эзэмшүүлнэ. Иймээс их сургуулийн багш нар нь дараах кейс судалгааны материалыг урьдчилан сайтар уншиж, доорх 3 асуултад хэлэлцүүлэгт оролцоход бэлэн байх шаардлагатай. <u>/Тус кэйсийг сургалтын бүртгэл баталгаажсаны дараа мэйлээр тусад нь илгээнэ/.</u> Харвардын Бизнесийн Сургуулийн кейс судалгааны материал “Cola Wars Continue: Coke vs. Pepsi in the Twenty-First Century” HBS Product #: 702442-PDF-ENG <i>Асуулт 1: Ундааны үйлдвэрлэлийн (хийжүүлсэн ба хийжүүлээгүй ундаа) салбарын бүтэц болон үнийн сүлжээ нь ямар байдаг вэ?</i> <i>Асуулт 2: Кока-Кола болон Пепсигийн өнөөг хүртэлх өрсөлдөөний стратегийн хамгийн сайн тал нь юу гэж та бодож байна вэ?</i> <i>Асуулт 3: АНУ-д хийжүүлсэн ундааны эрэлт буурч, хийжүүлээгүй ундаа илүү түгээмэл болж буй зах зээлийн нөхцөлд Кока-Кола болон Пепси тус бүр ямар бизнесийн стратеги баримтлах ёстой гэж та бодож байна вэ?</i>	

8) Бүртгэл: Доорх QR кодыг уншуулж бүртгүүлнэ үү.



9) Холбоо барих:

Утас: 7511-0879(Ext.3) , 8063-0879

Э-Мэйл: business@japan-center.edu.mn

Цахим хуудас: www.japan-center.edu.mn

Фейсбүүк хуудас: www.facebook.com/Mojc.business

